

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай

“Агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүн, тулгамдсан асуудал”-ын тухай Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюуны илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Агаарын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, шаардлагатай төсвийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэх.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Агаарын чанарыг сайжруулах талаар гаргасан идэвх, санаачилгыг дэмжиж урамшуулах, бохирдуулагч нь төлөх механизмыг хэрэгжүүлэх, хяналт хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр дүрэм, журмуудыг боловсронгуй болгож, үр ашгийг нэмэгдүүлэх;

2. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх, барилгажуулах ажлыг эрчимжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хур тундасны усыг хуримтлуулан усан сан байгуулах замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах;

3. Нийслэл болон бусад томоохон хот суурин газрын гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бууруулж, сайжруулсан түлшээр хангах ажлыг эрчимжүүлэх;

4. Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдлыг бууруулах шинэ техник, технологийг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх;

5. Нүүрсийг гүн боловсруулах / шингэрүүлэх, хийжүүлэх /, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх;

6. Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах асуудлын хүрээнд олон улсын стандартад нийцсэн сайн чанарын шатахууны хэрэглээг дэмжих, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;

7. Агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлж, үнэн, бодитой мэдээллээр ард иргэдийг шуурхай хангах нөхцөлийг бүрдүүлэх;

8. Агаарын бохирдлоос үүдэлтэй иргэний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөлөл болон өвчлөлийг бууруулах цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх.